



## МОНГОЛ УЛС

**Монгол Улс Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын Дүрмийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлсэнгүй. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нухчин дарав. Уул уурхайн улмаас үүсэж буй байгаль орчны доройтол малчдын эрхэд сөргөөр нөлөөлсөн хэвээр байна. Тэтгэврийн тогтолцооны шинэтгэл нийгмийн хамгаалал хүртэх эрхийг хамгаалсангүй. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хуулиар иргэдийн орон байртай байх эрхийг зөрчив.**

### ӨМНӨТГӨЛ

Эрх барьж буй Монгол Ардын Нам парламентын сонгуульд олонх болсон ч, сөрөг хүчин дутахааргүй санал авсан.

### ЯЛ ЗАВШУУЛАХ

Есдүгээр сард Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин албан ёсны айлчлал хийсэн. 2023 оны гуравдугаар сард Олон Улсын Эрүүгийн Шүүхээс баривчлах тогтоол гарсан ч Монгол Улс Ромын Дүрмийн гишүүн орныхоо хувьд Ерөнхийлөгч Путиныг баривчлах үүргээ биелүүлэлгүй, түүнийг хүлээн авав.<sup>1</sup>

### ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Эрх баригчдыг шүүмжилсэн сэтгүүлчид болон иргэдийн эсрэг гомдол гаргах, мөрдөн байцаахад Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийг ашиглаж байна. Цагдаагийн Ерөнхий Газрын мэдээллээр 2024 оны арван хоёрдугаар сарын 25-ны байдлаар ЭХ-ийн 13.14 буюу "худал мэдээлэл тараах" гэмт хэрэгтэй холбоотой 697 гомдол хүлээн авснаас 16 нь сэтгүүлчтэй холбоотой байна. Үүнээс дөрвийг нь яллагдагчаар татаж шийдвэрлэжээ.

Сэтгүүлчдийг, ялангуяа сонгуулийн жилд мөрдөн шалгах нь олширч, хэвлэлийн эрх чөлөөг нухчин дарж байна. Зариг мэдээний сайтын ерөнхий редактор Н.Өнөрцэцэгт хаалттай шүүх хуралдаанаар худал мэдээлэл тараасан зэрэг хэд хэдэн зүйл ангиар 4 жил 9 сарын хорих ял оногдуулав.

### СААТУУЛАГДСАН ЭТГЭЭДИЙН ЭРХ

Тавдугаар сард Эмнести Интернэшнлээс түр саатуулах, ялангуяа хүний халдашгүй, эрх чөлөөтэй байх эрхтэй холбоотой олон улсын хүний эрхийн хуулийн талаар amicus тойм бэлтгэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүргүүлэв.<sup>2</sup> Тус тоймд Цагдаагийн Албаны тухай хуулийн түр саатуулах хугацааны хязгаарыг зохицуулсан 26.2 дугаар заалт Үндсэн хуульд нийцсэн эсэх тухай багтаасан. Үндсэн хуулийн цэцээс зургаадугаар сард тус заалт нь Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэсэн.

### ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Уул уурхайн үйл ажиллагаа малчдын ундны ус, газрын эрх болон амьжиргаанд сөргөөр нөлөөлсөн хэвээр. Долоодугаар сард НҮБ-ын Уугуул иргэдийн эрхийн Тусгай Илтгэгч Монгол Улс дахь усны нөөц болон малын бэлчээрт үзүүлэх нөлөөнд санаа зовниж буйгаа илэрхийлж, уул уурхайн улмаас бий болж буй тоосжилт малын арьс, ноосны чанарыг доройтуулж, малчдын амьжиргаанд нөлөөлж байгаа тухай онцлов. Түүнчлэн малчид уламжлалт амьдралын хэв маягаас хөндийрч буйг тэмдэглэв.

### ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХ

#### Нийгмийн хамгааллын эрх

Засгийн газар 2005 оноос хойш тэтгэврийн хэмжээг нэмсээр ирсэн ч инфляцын төвшинтэй уялдсангүй. Тэтгэврийн хэмжээ нь ахмад настуудын амьжиргаанд хүрэлцэхгүй хэвээр байж, тэднийг ядууралд хүргэв. Тэтгэврийн хэмжээг инфляцтай уялдуулах зорилго бүхий зохицуулалт нь зарим ахмадын авах ёстой байсан тэтгэврийн хэмжээг бууруулсан.

#### Орон байртай байх эрх

2023 оны арван хоёрдугаар сард Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг яаравчлан баталсны улмаас 158 га газар дээрх 2000 гаруй өрхийг нүүлгэн шилжүүлж, дахиад олон өрх нөлөөлөлд өртөх эрсдэлд оров. Хэрэгжилтийн үеэр иргэдийн орон байртай байх эрхийг зөрчиж, оршин суугчдын мэдээлэл авах, урьдчилсан, мэдээлэлжсэн, чөлөөт байдлаар зөвшилцөх болон шударга нөхөх олговор авах зэрэг эрх хангагдсангүй.

<sup>1</sup> ["Mongolia: Putin must be arrested and surrendered to the International Criminal Court", 2 September](#)

<sup>2</sup> [Mongolia: Amicus Curiae Brief filed to the Constitutional Court of Mongolia \(Tssets\) on unlawful detention, 12 June](#)

Эмнести Интернэшнл нь хүн бүрд эрхийг нь эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн юм.

Бид эрх баригчид олон улсын эрх зүй, хэм хэмжээг хүндэтгэдэг, хариуцлагаа хүлээдэг, амлалтдаа хүрдэг дэлхий ертөнцийг бий болгохын төлөө ажилладаг.

Бид аливаа улс төрийн үзэл баримтлал, шашин, эдийн засгийн ашиг сонирхлоос ангид байж, гишүүд дэмжигчдийнхээ хандив тусламжаар санхүүждэг.

Монголын Эмнести Интернэшнл

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Их сургуулийн гудамж, #АВ төвийн 7 давхар 701 тоот

Утас/Факс: 976-7000-4705

members@amnesty.mn

www.amnesty.mn